



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3,244,464,405.00 (гурван тэрбум хоёр зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун таван) төгрөгийн балансын үнэ бүхий 2 (хоёр) ширхэг өрмийн машиныг “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлж хавсралтад заасны дагуу үнийг шинэчлэн тогтоож сэлбэгээр ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 569 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 34 дэх мөрөнд заасныг хүчингүй болсонд тооцсугай.

2.4. Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000127

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 08 дугаар сарын 21... өдрийн
 135 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 "МОНГОЛПРОСЦЕВМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Хөрөнгийн бүртгэлд авах шинэчлэн тогтоосон үнэ
1	Өрмийн машин СБШ-250 МНА-32 /Буровой станок №20/	2006	ш	1	2,188,123,119.00	2,188,123,119.00	0.00	10,000,000.00
2	Өрмийн машин СБШ-250 МНА-32 /Буровой станок №18/	2005	ш	1	1,056,341,286.00	1,056,341,286.00	0.00	20,000,000.00
				2	3,244,464,405.00	3,244,464,405.00		30,000,000.00
	Нийт дүн				(гурван тэрбум хоёр зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун тав)			(гучин сая)